



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/140

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн "Аймгийн 2025 оны төсвийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 27 дугаар тогтоол, Үнэлгээний хорооны 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 20 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААХААГ/20260201034 дугаартай "Хөхморьт сумын Дотуур байрны хайс хийх ажил"-ыг "Үнэлэмж-Алтай" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2025

8200010215